



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997-жылдын 3-дугаар
сарын 11-недең

Дугаар б.-бз

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Хүүхдийн урлан бүтээх төвийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар, Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн дэргэдэх Олон улсын хүүхэд-залуучуудын амралт-сургалтын зуслангийн дүрмийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ 11

Ж. НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргын 1997 оны
6500т захирамжийн хавсралт

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ
ТӨВИЙН ДҮРЭМ

ХЛБ 31

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монголын Хүүхдийн урлан бүтээх төв нь хүүхдийн чөлөөт цагийг бүтээлчээр зохион байгуулан тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, тэдэнд амьдрах арга ухаан, мэргэжлийн анхан шатны чиг баримжээ олгох төв мен.
2. Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн үндсэн зорилт нь Хүүхдийн эрхийн конвенцийн дагуу хүүхдийн хөгжих, эрүүл байж, нийгмийн ам өдралд оролцох эрхийг хэрэгжүүлэх, хүүхдийн нас бие, хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд тохирсон сургалт-практикийн ажлын шинюү холбэрээр явуулахад оршино.
3. Монголын Хүүхдийн урлан бүтээх төв нь үйл ажиллагавндаа Монгол улсын хууль, тогтоомж, хүүхдийн талаар төр застаас баримтлах бодлого шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.
4. Монголын Хүүхдийн урлан бүтээх төв нь Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын харьяанд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана. Тус төвийн захирлыг Нийслэлийн Засаг дарга томилж чөлөөлнө.
5. Төвийн захирал эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол улсын хууль тогтоомж, төр застийн шийдвэрт нийцүүлсэн тушаал гаргаж, биелэлтийг хангуулна. Төвийн захирал нь үйл ажиллагааныхаа талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнана.
6. Төв нь ерөнхий захирлын зөвлөлтэй байна. Зөвлөлийн тишүүдийг ерөнхий захирлын тушаалаар батлана. Зөвлөл нь төвийн дотоод журмыг баталж, өдөр тутмын үйл ажиллагаандaa мердлэг болгоно.
7. Төвийн дүрэм дэх зохион байгуулалтын бүтэц, удирдлагын орон тоог Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталж, хотын Санхүүгийн хэлтсээс санхүүжинэ.
8. Төв нь тэмдэг, албан бичгийн бланкийг тогтоосон журмын дагуу хэрэглэнэ.

Хоёр. Хүүхдийн урлан бүтээх төвийн үүрэг

1. Хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлж чимэх, чимэглэх урлаг, уран сайхан, гоо зүйн анхан шатны дэдал чадвар эзэмшигүүлэх.

2. Хүүхдийн хөгжих, эрүүл байтийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хүүхдийг өдөрт нэг удаа хөнгөн хооллож тэдний хүсэл сонирхлын дагуу суралцуулан авьяас чадварыг нь гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хүүхэд өөрийгөө үнэлэх, өөртөө итгэлтэй байх, бис дааж суралцах чадвартай болгох, амжилт бүтээлээрээ бахархах, харилсан бие биенээсээ суралцах, бусдыг хүндэтгэн хайллах зэрэг зан чанарыг төлөвлүүлэхэд туслах.

4. Хүүхдийн амьдралын арга ухаанд сурган, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, чөлөөт цагийг үр ашигтай зохион байгуулах, үндэсний соёл, зан заншилаа өвлүүлэх, улсын үндэстний амьдрал, соёл иргэншилтэй танилцуулах, үе тэнгийнхэнтэйгээ үерхэж нөхөрлөх, хамтран ажиллахад нь туслах.

5. Авьяастай хүүхдийг нээн илрүүлж хөгжүүлэхэд мэргэжлийн туслацаа үзүүлэн зохих шатны сургуульд элсэхэд туслах.

6. Хүүхдийн нас, бие сэтгэхүйн онцлогт төхирсон төрөл бурийн сонирхолтой уралдаан тэмцэнийг төвийн болон улсын хэмжээнд зохион байгуулах.

7. Хүүхдийн дунд төвлөрсөн арга хэмжээ, соёл хүмүүжлийн ажил зохион байгуулахад хамт олон, олон улсын байгууллагээ, хувь хүмүүстэй хамтран ажиллах.

8. Аймаг, орон нутагт ажиллаж байгаа хүүхдийн соёлын төвийн үйл ажиллагааг дэмжин туслах, хөдөө орон нутгийн багш, сурагчдын хүсэлтийн дагуу сургах, хүүхдийн үзэсгэлэн Улаанбаатар хотод зохион байгуулахад туслах.

9. Гадаадын байгууллагатай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх, уран бүтээлийн хамтлаг харилсан солилцох.

10. Хүүхэдтэй ажилладаг багш нар, боловсон хүчинийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, дадлагажуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх.

11. Хүүхдийн талаарх олон талт ажлыг бусад байгууллага, олон нийтэд өргөн сурталчлан хүргэх.

12. Сургалт-хүмүүжлийн ажлын үр нleөг дээшлүүлж, эцэг-өх-багш-хүүхдийн бүтээлч, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

13. Байгууллагын материаллаг бааз, сургалтын зардлыг бэхжүүлэн нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой арга хэмжээ авч, өмчийн хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.

14. Тус төв нь өөрийн байгууллагын дэргэд Олон улсын хүүхэд-залуучуудын амралт-сургалтын төвийг байгуулж ажиллуулна:

Гурав. Хүүхдийн урлан бүтээх төвийн эрх

1. Улсын болон аж ахуйн нэгж байгууллагуудтай үйлчилгээний үйл ажиллагаа явуулж, олон орлого ба батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу захирэн зарцуулах.

2. Хүүхдийн чөлөөт цагур чадвартай холбогдсон асуудлаар санал боловсруулан дээд байгууллага, төр засагт уламжлах.
3. Хүүхдийн эрх ашиг болон эрхэлсэн ажлын холбогдолтой бусад асуудлаар шаардлагатай мэдээ материалыг байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнээс авах.
4. Монгол үлсын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн нэгж, үндсэн нэнжийн газруудад олгогдсон бусад эрх өдлэнэ.
5. Монголын Хүүхдийн урлан бүтээх төв нь цаашид төлбөртэй сургалт явуулж, мөн үйлчилгээ зохион байгуулсан нэмэгдэл орлогын эх үүсвэр бий болгон хүүхдийн авьяас чадвар, материаллаг баазыг бэхжүүлэхэд зарцуулна.

Нийслэлийн Засаг даргын 1997 оны
6 дугаар засхиргийн 2-р хавсралт.

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН
ДЭРГЭДЭХ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН СУРГАЛТ
АМРАЛТЫН "ДЭЛХИЙ АЗИ" ЗУСЛАНГИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл.

1. Сургалт-амралтын "Дэлхий Ази" зуслан нь (цаашид зуслан гэх) хүүхэд залуучууд нэн ялангуяа өнчин, хагас өнчин, ядуу зүдүү амьдралтай гэр оронгуй тэнэмэл хүүхдүүдийг сургалт амралтын хосолсон хэлбэрээр сургалтанд хамруулж, ингэснээр тэдний сурь болосвролыг бэлжүүлэх, хөдөлмөрийн хүмүүжил олгож, юмханаар юм хийж, амьдрах арга ухаанд сургах, тэдэнд нийгмийн харилцаа, иргэний хүмүүжил төлөвшүүлэх зэрэгт туслах зорилго бүхий хүүхэд залуучуудын байгууллага болно.

2. "Дэлхий Ази" зуслан нь үйл ажиллагаагаа бие даан явуулах эрх бүхий хуулийн этгээд мен.

3. Монгол улсын Үндсэн хууль, хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын конвенц, бусад холбогдох хууль тогтоомж болон нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын захирамж, шийдвэрийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгоно.

4. Хүүхэд залуучуудын хамтын үйл ажиллагааг дэмжин туслах хүсэл эрмэлзэлтэй дотоод, гадаадын буяны байгууллага, аж ахуйн нэгж хувь хүмүүс тус зусланг өргөжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцож болно.

5. Зуслан нь тогтоосон журнаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас, эмблем хэрэглэх ба банкинд өөрийн харилцах данстай байна.

Хоёр. Зуслангийн үйл ажиллагааны үндсэн зорилго чиглэл:

1. Өөрийн орны хүүхэд залуучуудад улс төр, үзэл бодлоос үп хамааран хамтран амьдарч ажиллаж сурх, эх оронч, нийтэч сэтгэлгээ төлөвшүүлэх, гадаад орны хүүхэд залуучуудтай үерхэж, нөхөрлөх бие биенийхээ зан заншил, сайн сайхан зүйлээс харилцан суралцах зэрэгт чиглэнэ.

2. Зуслан нь хүүхэд залуучуудад Монгол орныхоо байгаль, түүх, соёлын үнэт зүйлс, ард түмнийхээ зан заншил, тэдний хийж бүтээсэн зүйлстэй танилцуулахын зэрэгцээ тэдний бүтээлч сэтгэлгээ, мэдлэг чадварын хүрээг нь өргөтгөхэд сургалт-амралтын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

3. Зуслан нь хүүхэд залуучуудын талаар явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх, авьяас бэлгийг нээж хөгжүүлэх албан бус сургалт явуулж, хөдөлмөрийн хүмүүжил олгоход ажлаа чиглүүлнэ.

4. Зуслан нь ардчилсан чөлөөт хэлбэрээр зохион байгуулагдсан хөгжил хүмүүжлийн зохистой орчин, сурган хүмүүжүүлэх эвсэг, бүтээлч хамт олны цогц байгууллага байна.

5. Тус зуслан нь хүүхэд запуучуудыг өх орны байгаль орчинтой танилцуулахын зэрэгцээ цогцолборыг түшиглэн байгуулгдах Амьтдын өртөнц, дэлхийн уран барилга, дэлхийн гайхамшиг, байгалийн музейнүүдийг үзүүлж байгаль экологийн мэдлэгийг нь гүнзгийрүүлэх ажил зохионо.

6. Зуслан үйл ажиллагаанд байнга шинийг эрэлхийлж, удирдлага, зохион байгуулалт, сургалт хүмүүжлийн арга хэлбэрээ боловсронгуй болгон олон улсын хүүхэд запуучуудын байгууллагуудтай хамтран ажиллаж тэдний дэвшинтэй арга туршлагаас тасралтгүй суралцана.

7. Зуслан нь хүүхэд запуучуудыг ая тухтай зөв боловсон амараах, харилцан суралцаж хамтран ажиллахад туслах зорилго чиглэлээр хэрэгжүүлэх тусгай программ, ажлын нарийвчилсан хөтөлбөртэй байна.

Гурав. Зуслангийн удирдлага, зохион байгуулалт:

1. Зуслангийн үйл ажиллагаанд Монголын хүүхдийн урлан бүтээх төв ерөнхий хяналт тавьж чиглэл удирдамж өгнө.

2. Зуслангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж явуулах гүйцэтгэх захирлыг нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газартай зөвшилцсний үндсэн дээр Хүүхдийн урлан бүтээх төвийн ерөнхий захирал томилж, чөлөөлнө.

3. Зуслангийн орон тоо бүтэц зохион байгуулалтыг гүйцэтгэх захирал боловсруулж урулан бүтээх төвтэй зөвшилцсний дагуу санхүүгийн хэлтсээр батлуулна.

4. Зуслангийн ерөнхий захирал нь өөрийн санаачлагваар захирлын дэргэдэх зөвлөлийг байгуулж болно. Уг зөвлөл нь зуслангийн үйл ажиллагаанд зөвлөх эрхтэй оролцно.

Дөрөв. Зуслангийн эрх, үүрэг:

1. Зуслангийн эрх үүрэг Монгол улсын хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудаар зохицуулагдана.

2. Зуслан улсын төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлан балансыг хугацаанд нь санхүүгийн хэлтэст гаргаж хянуулна.

3. Зуслан олон улсын хүүхэд запуучуудын байгууллага, хүмүүстэй ажил төрлийн харилцаа холбоо тогтоож, гэрээ хэлцэл байгуулж болно.

4. Зуслан нь хүүхэд запуучуудыг ая тухтай амараах, сурч боловсорч, соёлжих бүхий л бололцоо нөхцлийг хангана.

5. Тус зусландаа амарч байгаа хүүхэд запуучуудын эрүүл мэндэд онцгой анхаарал тавьж, эмнэлэг хүнсний хяналтын байгууллагуудтай байнгын харилцаатай ажиллаж, ариун цэврийн шаардлагыг дээд зэрэгт тавина.

6. Зусландаа төвлөрсөн тадаад дотоодын хандив, тусламжийн хөрөнгийг Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн хяналтын дор бие даан зарцуулна.

7. Зуслан санхүүгийнхээ чадамжийг бэжжүүлэхийн тулд хууль тогтоомжийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа явуулна.

8. Боловсон хүчнийг ажилд авах, ажлын үр дүнгээр шагнаж урамшуулах, захиргааны арга хэмжээ, ажлаас чөлөөлөх эрхийг зуслангийн гүйцэтгэх захирал эдэлнэ.

9. Өөрийн байгууллага болон хүүхэд залуучуудын эрх ашигтай холбогдсон аливаа маргааныг гүйцэтгэх захирал зохицуулах бөгөөд ут зөрчил маргаан нь хуульд хөршилсан тохиолдолд хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлна.

Тав. Зуслангийн санхүү, хөрөнгийн зохицуулалт,

хяналт шалгалт:

1. Зуслангийн санхүү нь улсын төсвийн хөрөнгө, ивээн тэтгэгч гадаад, дотоодын байгууллага, хүмүүсийн хандив, тусlamж, аж ахуйн үйл ажиллагаа явуулснаас орсон орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

2. Улсын төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлан баланс гаргана.

3. Хандив, тусlamж, аж ахуйн үйл ажиллагаа явуулсан болон бусад эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтсийн хяналтын дор хүүхэд залуучуудын эрх ашигийг тулд биэ даан зарцуулж, санхүүгийн холтост тайлагнаж байна.

4. Зуслангийн санхүүгийн үйл ажиллагаанд Монголын хүүхдийн урлан бүтээх төв өрөнхий хяналт тавина.

5. Зуслан бүх үйл ажиллагаагаа ил тод явуулж хэвлэл мэдээллээр сурталчилж байна.

6. Жилийн эцэст зуслангийн санхүүгийн үйл ажиллагааг санхүүгийн хэлтсээр шалгуулж, дүгнэлт гаргуулж байна.

Зургаа: Зусланг татан буулгах журам:

1. "Дэлхий—Ази" зуслан дараах тохиолдолд татан буугдана.

а/ төрийн өмч болох байшин барилга эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьчлагдах буюу өөр байгууллагад шилжвэл

б/зуслан санхүүгийн үйл ажиллагааг явуулах боломжгүй болсон бол

2. Зусланг татан буулгах асуудлыг Монголын хүүхдийн урлан бүтээх төв, эрх бүхий байгууллагад санал гаргаж болно

3. Зуслан татан буугдсан тохиолдолд тайлан балансыг гарган улсын бүртгээс хасуулах, төлбөр тооцоог барагдуулах асуудлыг зуслангийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нар хариуцна.

4. Зуслан татан буугдсан тохиолдолд олон улсын хүүхэд залуучуудын байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.